

# 1

## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛЬ

**Б. Сувд**

**60**

жилийн ойгоо тэмдэглэж байгаа Монгол Улсын Их Сургуулийн ууган сургуулиудын нэг бол Эдийн Засгийн Сургууль, тавь гаруй жилийн түүхтэй. 1947 онд МУИС-ийн нийгмийн ухааны салбарт эдийн засгийн анхны ангийг нээнээр улс оронд эдийн засгийн дээд мэргэжилтнийг бэлтгэх уурхай болсон МУИС-ийн ЭЗС-ийн үндэс суурь тавигдсан байна.

1947-1958	МУИС-ийн нийгмийн ухааны салбар
1958-1959	МУИС-ийн Эдийн засгийн факультет
1959-1967	Эдийн засгийн дээд сургууль
1967-1991	МУИС-ийн Эдийн засгийн факультет /1967-1988/ МУИС-ийн Худалдааны эдийн засгийн факультет /1974-1988/
1991-1996	МУИС-ийн Эдийн засгийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн
1996 оноос	МУИС-ийн Эдийн засгийн сургууль

1996-1998 онуудад боловсролын тогтолцоог дэмжих Европын холбооны ТАСИС төслийг хэрэгжүүлсэнээр бакалаврын сургалтыг Европын орнуудын дундаж түвшинд ойртуулсан иж бүрэн шинэчлэлт хийж, багш нарынхаа мэргэжлийг өндөр хөгжилтэй орнуудын их дээд сургуулиудад дээшлүүлж, гадаад хэлний бэлтгэлийг сайжруулж чадсан билээ.

Одоо тус сургуульд бакалавр, магистр, докторын 3 түвшний сургалтыг явуулж байна. Нийт 1500-аад оюутан, 200 гаруй магистрант, докторант суралцаж байна.

ЭЗС нь дээд боловсролын магадлан итгэмжлэл хийлгэсэн. Тус сургууль Монголд анх удаа нягтлан бодох бүртгэл, менежментийн хичээлийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийлгээд байна. ЭЗС-ийн хамт олон төрөлх сургуулиа зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн өндөр мэдлэг боловсрол бүхий тэргүүний мэргэжилтэн бэлтгэдэг, онол практикийн тулгамдсан

асуудлыг шийдвэрлэхэд жинтэй хувь нэмэр бруулдаг, олон улсын жишигт хүрсэн шилдэг тэргүүний сургууль болгохын төлөө чармайн ажиллацааж байна.

ЭЗС өнөөдрийн байдлаар нийт 100 гаруй багш, ажиллагадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрийн дотор Монгол улсын ШУА-ийн жинхэнэ гишүүн 2, эдийн засгийн шинжлэх ухааны доктор 5, эдийн засгийн ухааны боловсролын доктор 24 ажиллаж байгаа юм. Багшлах бүрэлдэхүүний дотор 1-5 жил ажиллаж буй багш 18, 6-10 жил ажиллаж буй багш 25, 11-15 жил ажиллаж буй багш 7, 16-20 жил ажиллаж буй багш 6, 20-иос дээш жил ажиллаж буй багш 29 байна. ЭЗС-д ажиллаж буй багш нарын 10 нь тэргүүлэх профессорын, 13 нь профессорын, 13 нь дэд профессорын, 12 нь ахлах багшийн, 30 нь багшийн, 7 нь дагалдан багшийн орон тоон дээр ажиллаж байгаа юм. Суулийн жилүүдэд тус сургууль АНУ, Их Британи, Голланд, Австрали зэрэг орнуудад магистрийн зэрэг хамгаалсан шинэ залуу багш нараар эгнээгээ өргөжүүлсэн билээ.

Эдийн засгийн сургууль нь үүсэн байгуулагдсан цагасаа хойш эдийн засгийн чиглэлийн сургалт, судалгааны томоохон төвийн үүргийг гүйцэтгэсээр ирсэн билээ. Тус сургуульд эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр гадаад, дотоодод эрдмийн зэрэг, цол хамгаалсан шилдэг тэргүүний олон эрдэмтэн ажилладаг.

Тус сургууль бүрэлдэн тогтсон оюуны өндөр потенциалдаа тулгуурлан эрдмийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулж, эдийн засгийн шинжлэх ухааны тодорхой чиглэлүүдээр гүнзгийрч, нарийн мэргэшсэн, онолын өндөр мэдлэгтэй, чадварлаг эрдэмтдийг бэлтгэн гаргахын сацуу дараахь чиглэлүүдээр эрдэм шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Онолын болон суурь судалгаа
- Засгийн газар, шинжлэх ухааны байгууллагуудын захиалгат төсөлт ажлууд
- Аж ахуйн нэгжүүдийн захиалгат судалгаа, шинжилгээний ажлууд.

Манай сургуулийн багш өөрсдийн идэвхи оролдлогоор эрдмийн зэрэг цол хамгаалахын зэрэгцээ улс, олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл тавьж, эрдэм шинжилгээний олон арван өгүүлэл, нэгэн сэдэвт бүтээлийг туурвин гаргасан билээ.

Тус сургуулийн хамт олон эдийн засгийн сургалт судалгааны чиглэлээр өөрийн эзэлж буй тэргүүлэх байр суурийг бататган бэхжүүлэхийн зэрэгцээ, судалгаа шинжилгээний ажлыг олон улсын жишигт хүргэх зорилт тавин ажиллаж байна.

ЭЗС-ийн хэмжээнд сургалтын ажлыг зохион байгуулах, түүнийг өдөр тутмын үйл ажиллагааны удирдлагаар хангах үүргийг тус сургуулийн сургалтын алба гүйцэтгэдэг. Тус сургууль нь бакалаврын сургалтыг өдрийн ба оройн, магистр, докторын сургалтыг өдөр, эчнээ, экстернат хэлбэрээр явуулдаг.

Эдийн засгийн сургуулийн бакалаврын түвшний сургалтад хамрагдаж буй оюутан суралцах хугацааныхаа түршид 128 кр цагийн, магистрын түвшинд 30 кр цагийн, доктор (Ph)-ын түвшний сургалтад 60 кр цагийн агуулга бүхий хичээлүүдийг үзэж судлах ёстай.

Сургалтын алба өөрийн үйл ажиллагааг дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Бакалаврын сургалтыг боловсронгуй болгох,
- Магистр, докторын сургалтыг хөгжүүлэх,
- Шилдэг тэргүүний багш нартай байх.

Тус сургуулийн сургалт эрдэм шинжилгээний үйл ажиллагаа нь бүхэлдээ төгсөгчдөд сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйчилгээний аль ч салбарт ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар, дадал, судалгаа шинжилгээний аргазүйг эзэмшүүлж, иргэний өндөр соёлыг төлөвшүүлэхэд чиглэж байгаа билээ.

**Эдийн засгийн онолын тэнхим** нь анх МУИС-ийн Улс төрийн эдийн засгийн ухааны тэнхим нэртэйгээр 1954 онд байгуулагдсан ба 1991 оноос Эдийн Засгийн Онолын тэнхим гэж нэрлэгдэх болсон. Тэнхим оршин тогтоносон 46 жилийнхээ туршид тэнхимийн бүрэлдэхүүнийг гадаад, дотоодын дээд сургууль төгссөн чадварлаг хүмүүсээр сэлбэж, одоогийн бүтэц бүрэлдэхүүндээ хүрсэн билээ. Тус тэнхимийн багш нараас олон хүн Япон, Австрали, Англи, Австри, АНУ, Солонгосын их сургуулиудад магистр, докторын зэргийг хамгаалсан ба хамгаалахаар суралцаж байна.

1993-1994 оны хичээлийн жилээс эхлэн тус тэнхимээс Микро болон Макро эдийн засгийн хичээлийг 3 тувшинд, Хөгжлийн эдийн засаг, Эконометрикс, Микро, Макро эдийн засагт эконометрикийг хэрэглэх нь, Мөнгөний онол ба бодлого, Эдийн засгийн сэтгэлгээний түүх, Эдийн засгийн өсөлтийн онол болон Олон улсын эдийн засаг, Менежментийн экономикс, Байгаль орчны экономикс зэрэг хичээлүүдийг бакалаврын өдөр, орой, эчнээ ангиудын оюутнуудад, эдийн засаг III, IV, Микро, Макро, Шилжилтийн экономикс, Олон улсын экономикс, Менежментийн экономикс болон Олон улсын мөнгөний онол, Өсөлтийн онол, Хөгжлийн Олон Улсын Санхүү зэрэг хичээлүүдийг магистрантуудад зааж байна. Одоо тус тэнхимээс Эдийн Засгийн Онолын мэргэжлийн ангиудад 29 төрлийн хичээл зааж байгаагийн нэлээд хэсэг нь Монгол улсад анхлан заагдаж буй шинэ хичээлүүд юм.

Одоо тус тэнхимийн багш нар СЭЗЯ-ны захиалгаар "Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал, шалтуур үзүүлэлт" сэдэвт эрдэм шинжилгээний тесэл, Азийн сангийн санхүүжилтээр "Монголын өрх гэрүүдийн эмзэг байдлын судалгаа"-г хийж байна.

Эдийн засгийн онолын мэргэжлээр төгсөгчид нь улс орны эдийн засагт гарч буй шинэчлэлт, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх, эдийн засгийн бодлого боловсруулах, их дээд сургуульд багшлах, судалгаа хийх аль нэг албан байгууллагын эдийн засгийн бодлогыг хариуцан ажиллах, шинээр байгуулагдах аж ахуйн нэгжүүдэд төсөл боловсруулж, зардал ашгийг нягтлан удирдаж зохион байгуулах бүрэн чадвартай мэргэжилтнүүд болон бэлтгэгддэг бөгөөд эдийн засгийн аль ч салбарт ажиллах чадварыг эзэмшдэг юм.

**Математик - Компьютерийн тэнхим** нь 2000 онд Математикийн тэнхим ба Мэдээлэл үйлчилгээний төвийг нэгтгэсний үндсэн дээр байгуулагдсан. Мэдээлэл үйлчилгээний төв нь 1989 онд статистикийн тэнхимийн харьяанд байгуулагдсан ба 1994 оноос Мэдээлэлээсүйн тэнхим, 1996 оноос Мэдээлэл үйлчилгээний төв нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байв. Математикийн тэнхим нь 1993 онд байгуулагдсан ба 1996-2000 онуудад Экономикс - Эконометрикийн салбарын бүрэлдэхүүнд үйл ажиллагаагаа явуулж байжээ.

Тус тэнхимийн багш нар дээд тоо, үйлдлийн шинжилгээ, мэдээлэл зүй зэрэг ерөнхий эрдмийн, эдийн засгийн математик загварчлал, системийн програмчлал, санхүүгийн мэдээлэл боловсруулалт, статистикийн мэдээлэл боловсруулалт, менежментийн мэдээллийн систем, маркетингийн мэдээллийн систем, санхүүгийн мэдээллийн систем, мэдээллийн бааз ба систем зэрэг мэргэжлийн суурь хичээлүүдийг зааж байна.

Тус тэнхимээс дараах үндсэн чиглэлүүдээр судалгаа шинжилгээний ажлуудыг хийж байна. Үүнд:

- Эдийн засгийн математик загварчлал,

- глобаль оптимизацийн хэрэглээ,
- эдийн засгийн салбаруудын санхүү, бүртгэл, удирдлагын мэдээлэл боловсруулалт ба мэдээллийн системийг боловсронгуй болгох.

**Статистик - Хүн ам зүйн тэнхим.** 1960-1961 оны хичээлийн жилээс Эдийн засагч-статистикч мэргэжлээр оюутан элсүүлж, дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлснээр Статистикийн тэнхим байгуулагджээ. Тус тэнхим эдийн засагч-статистикч мэргэжлээр 1964 онд анхныхаа төгсөлтийг 27 оюутантайгаар хийж байсан бол 1990-1991 оны хичээлийн жилээс Статистикч-Хүн Ам Зүйч мэргэжлээр элсэлт авч 1993-1994 оны хичээлийн жилд дээрх мэргэжлээр анхны төгсөлтөө хийж байлаа. Өнгөрсөн хугацааны туршид тус тэнхим нь дээрх хоёр мэргэжлээр бакалаврын зэрэгтэй 900-аад дээд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж гаргаад байна.

Тус тэнхимийн харьялалд ажилладаг Хүн ам зүйн сургалт, судалгааны төв нь 1990 онд Хүн ам зүйн лаборатори нэртэйгээр байгуулагдаж, улмаар 1993 онд НҮБ-ын Хүн Амын Сангийн техник, эдийн засгийн туслапцаатайгаар одоогийнхоо зохион байгуулалтад шилжсэн юм. Тус төв нь төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, гадаад орнуудын их, дээд сургуулиудын холбогдох салбаруудтай өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлж, НҮБ-ын Хүн Амын Сангаас Монгол Улсын Засгийн Газартай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд амжилттай оролцон, энэ чиглэлээр хийгдэж буй төслүүдийг хэрэгжүүлэгч гол байгууллага болон ажиллаж байна.

**Статистик-Хүн амзүйн тэнхимээс эдийн засгийн мэргэжлээр суралцаж байгаа нийт оюутнуудад магадлалын онол-математик статистик, статистикийн онол, бизнес-эдийн засгийн статистик, нийгмийн судалгааны арга зүй зэрэг мэргэжлийн суурь хичээлүүд, ХАА-н статистик, хүн ам зүйн үндэс, хүн ам ба хөгжил, хүн амын бодлого, хөтөлбөр, судалгааны мэдээлэл боловсруулалт ISSA, SPSS зэрэг хичээлүүдийг сонгон суралцах хэлбэрээр зааж байна.**

Тус тэнхимийн багш, оюутнуудад сүүлийн жилүүдэд олон улсын болон дотоодын төсөлт ажлууд, эрдэм шинжилгээний ажилд идэвхтэй оролцож байгаа ба нийт 40 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажил, 10-аад сурх бичиг, гарын авлагыг бэлтгэн гаргаад байна. 1996 оноос Монголын хүн амын сэтгүүлийг улирал тутамд эрхлэн гаргах болсон. Тус тэнхим нь хүн ам зүйн болон статистик шинжилгээний PEOPLE, DEMPROJ, PAS, MORTPAK, WORKERS багц программууд бүхий 15 компьютер, сүлжээний хэвлэх машин бүхий лабораторийн техник, хэрэгсэлтэйгээр сургалт, судалгааны ажил явуулж байна.

**Маркетинг - Олон улсын тэнхим** нь 1959 онд худалдааны эдийн засгийн тэнхим нэртэйгээр байгуулагдсан. 1967 онд ЭЗФ-ын санхүү зээлийн тэнхимтэй нийлж, 1971 онд дахин байгуулагдсан ба 1988 онд ЭЗФ-ын УАА-н төлөвлөлтийн тэнхимтэй нэгдэж, салбарын эдийн засаг төлөвлөлтийн тэнхим болон ажилласан. 1990 оны 9-р сараас уг тэнхимээс салж Зах зээл судлалын тэнхим, 1993 оноос нэрээ өөрчилж маркетингийн тэнхим болсон. 1963-2001 онуудад худалдааны эдийн засагч, худалдааны нягтлан бодогч, баарууд судлаач, нийтийн хоолны инженер технологич, маркетингийн менежер, гадаад худалдааны эдийн засагч, гадаад худалдааны менежер зэрэг мэргэжлээр 2 мянга гаруй хүн төгссөн байна.

Тус тэнхимээс маркетингийн үндэс, хөраглагчийн зан төлөв, маркетингийн менежмент, үйлчилгээний маркетинг, аялал жуулчлалын маркетинг, байгууллагын маркетинг, олон улсын маркетинг, идэвхжүүлэлтийн менежмент, дотоод худалдаа, олон улсын худалдаа, олон улсын худалдааны үнэ тариф, олон улсын тээвэрлэлт, маркетингийн судалгаа, олон улсын хөрөнгө оруулалт зэрэг хичээлүүдийг эрхлэн заадаг. Төгсөгчдийг маркетингийн менежер, гадаад худалдааны менежер мэргэжлээр бэлтгэж байгаа юм.

Тус тэнхим нь захиалгат эрдэм шинжилгээний хэд хэдэн төслийг хийж гүйцэтгэн захиалагчид шилжүүлж өгсөн ба одоо "Бөөний худалдаа-маркетингийн оновчтой тогтолцоо бурдүүлэх үндэслэл, арга зам", "Монгол улсын гадаад худалдааны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх арга, аргачлалыг боловсронгуй болгох асуудалд" сэдэвт засгийн газрын захиалгат эрдэм шинжилгээний төслийг гэрээт ажлын байдлаар гүйцэтгэж байна.

**Менежментийн тэнхим** нь 1959 онд УАА-н тэнхим нэртэйгээр байгуулагдсан. 1988 онд Худалдааны эдийн засгийн тэнхимтэй нэгдэж салбарын эдийн засаг, төлөвлөлтийн тэнхим, 1990 оноос биеэ даасан Менежментийн тэнхим болон үйл ажиллагаагаа явуулж байна. 1991 оноос багш нарын аттестатчилал явуулж бүрэлдэхүүнээ бэхжүүлсэн. Дэлхийн банктай хамтран "Макро эдийн засгийн менежмент" сэдвээр сургалт зохион байгуулж, багш нарынхаа зах зээлийн эдийн засаг, менежмент болон англи хэлний мэдлэгийг дээшлүүлсэн. Дараа нь эдийн засаг, менежментийн сургалт эрхэлдэг сургуулиудын консорциумын шугамаар менежментийн сургалт өөрчлөх төсөлд оролцож, сургалтын төлөвлөгөө хичээлийн агуулгаа өөрчилсөн юм.

Тус тэнхим Менежментийн онол, Үйлдвэрлэлийн менежмент, Аж үйлдвэрийн эдийн засаг, ХАА-н эдийн засаг, Хүний нөөцийн удирдлага, Байгууллагын зан төлөв, Удирдлагын шийдвэр, Монголын ба Олон улсын эдийн засгийн орчин, Олон улсын менежмент, Монголын бизнесийн удирдлага, Стратегийн менежмент, Бизнес төлөвлөлт зэрэг хичээлүүдийг эрхлэн заадаг. Одоогийн байдлаар тус тэнхим нь менежмент-үйлдвэрлэлийн эдийн засгийн удирдлагын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг. Тус тэнхмийг байгуулагдсан цагаас хойш дээр дурдсан мэргэжлээр 1200-аад хүн төгссөн.

Тус тэнхим нь сургалтын ажлын зэрэгцээ эрдэм шинжилгээний төсөлт ажлуудыг гүйцэтгэн, гадаад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай санал зөвлөгөө солилцон хамтран ажилладаг. Одоогийн байдлаар "Макро эдийн засгийн менежмент, нутаг дэвсгэрийн төлөвлөлт, хөгжил, бизнес төлөвлөлт, менежмент"-ийн чиглэлээр судалгааны ажил хийж байна.

**Нягтлан бодох бүртгэлийн тэнхим** нь 1959 онд Эдийн засгийн дээд сургуулийн "Бүртгэл-санхүүгийн тэнхим" нэртэйгээр үүсэн байгуулагдаж, 40 гаруй жилийн туршид Монгол улсад нягтлан бодох бүртгэл-санхүүгийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

Тэнхимээс бакалавр, магистр, докторын сургалтыг явуулахын зэрэгцээ, төгсөгчдийнхээ мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх асуудалд онцгойлон анхаарч, мэргэжлийн сургалтын бодлогыг тодорхойлж, сургалтын стандартыг боловсруулах тэргүүлэх байгууллагын үүрэгтэйгээр ажилладаг. Өнгөрсөн 40 гаруй жилд тус салбарыг 3600 гаруй мэргэжилтэн төгссөн нь Монгол Улсын төрийн удирдлага болон бизнесийн салбарт үр бүтээлтэй ажиллаж Нягтлан бодох бүртгэл, санхүү аудитын тогтолцоог олон улсын түгээмэл жишигт нийцүүлж шинэчлэх, Олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг гардан гүйцэтгэж байна.

Салбарын багш нар Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулж санхүүжүүлсэн "Монгол Улсын бүртгэл аудитын чадавхийг хөгжүүлэх" хоёр шатны төсөлд бүрэн хамрагдан мэргэжлийн цуврал семинаруудад суралцаж мэргэжлээ дээшлүүлсэн бөгөөд "Монгол Улсын Бүртгэл санхүү, банкны тогтолцоо" 1998-1999 онд "Бизнесийн болон ашгийн бус байгууллагын бүртгэл-тайлагнал аудитын тогтолцоо" сэдэвт төслийн гэрээт ажлыг 2000-2001 онд Сангийн Яамны захиалгаар гүйцэтгэж зөвхөн сүүлийн 5 жилд мэргэжлийн ном, сурх бичиг 10 гаруйг бичиж, 5 номыг орос, англи хэлнээс хамтран орчуулж хэвлүүлэн нийтийн хүртээл болгосны хамт оюутны бие даан суралцах болон алсын зайн сургалтын материал, гарын авлагыг

боловсруулсан ба цаашдаа зааж буй хичээл тус бүрээр оюутан болон багш наарт зориулсан сургалтын багц материалыг иж бүрдэлээр бэлтгэх зорилт тавин ажиллаж байна.

Тус тэнхим нь 2001 онд Нягтлан бodoх бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлберийн магадлан итгэмжлэлийг анх удаа хийлгэсэн. Монгол Улсын Санхүү Эдийн Засгийн Яам, Нягтлан бodoх бүртгэлийн мэргэжлийн Зөвлөл, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон дотоод, гадаадын Их дээд сургуулийн мэргэжлийн тэнхим, эрдэмтэн багш наартай ажил төрлийн байнгын холбоотой ажиллаж, хамтарсан семинар, онол практикийн бага хурлыг жил бүр зохион байгуулдаг.

Төрийн болон Бизнесийн удирдлагад бүртгэл-аудитын ажлын үүрэг, нэр хүнд өсөж, түүнд тавигдах шаардлага өндөржиж байгаа өнөөгийн нөхцөлд бэлтгэж буй мэргэжилтний суурь болон мэргэжлийн бэлтгэл, практик чадварыг Олон улсын түгээмэл жишигт хүргэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

**Санхүүгийн тэнхим** 1959 онд ЭЗДС-ийн ЭЗФ-ийн бүрэлдэхүүнд бүртгэл санхүүгийн тэнхим нэртэй байгуулдсан ба 1965 онд санхүү зээлийн тэнхим гэсэн нэртэйгээр биеz даасан тэнхим болон зохион байгуулдсан юм. Тус тэнхим нь өнгөрсөн хугацаанд ЭЗС-ийн бүтэц зохион байгуулалтад гарсан өөрчлөлттэй холбоотойгоор 1997-1998 онд Санхүүгийн салбар, 1999 оноос Санхүүгийн тэнхим нэртэйгээр зохион байгуулдган ажиллаж байна. 1957 оноос эхлэн санхүүгийн мэргэжлээр элсэлт авч, 1960 оноос банкны ангийг шинээр нээсэн билээ.

Тус тэнхимийн багш нар санхүүгийн үндэс, аж ахуйн нэгжийн санхүү, санхүүгийн менежмент, санхүүгийн хяналт шалгалт, төсвийн төлөвлөлт ба макро загвар, банкны менежмент, ОУВС, татварын онол ба тогтолцоо зэрэг мэргэжлийн суурь хичээлүүдийг зааж байна. Төгсөгчдийг санхүү, банк, төсөв санхүү, татвар, даатгалын мэргэжлээр бэлтгэж байгаа юм.

Тус тэнхим нь захиалгат эрдэм шинжилгээний хэд хэдэн төслийг хийж гүйцэтгэн захиалагчид шилжүүлж өгсөн ба одоо "Монгол улсын макро эдийн засгийн санхүүгийн хөтөлбөр боловсруулах асуудал" сэдэвт засгийн газрын захиалгат эрдэм шинжилгээний төслийг гэрээт ажлын байдлаар гүйцэтгэж байна.

**Биеийн тамирын тэнхим** нь 1948 онд МУИС-ийн ректорын тушаалаар цэрэг биеийн тамирын тэнхим нэртэйгээр байгуулдсан Монгол улсын биеийн тамирын ууган тэнхим юм. 1959 оноос тэнхимийн дэргэд спорт клуб байгуулан ажиллаж, оюутан багш ажилчдын дунд нийтийн биеийн тамир спортын арга хэмжээг өргөн хүрээтэй зохион байгуулан спортын, уралдаан тэмцээнд бие даан оролцож, олон тооны авьяаслаг залуу тамирчдыг улс эх орондоо бэлтгэн гаргаж ирсэн билээ.

Тэнхим байгуулдан ажилласан хугацааны туршид бэлтгэсэн шавь нараас спортын гавьяат тамирчин 10, олон улсын хэмжээний мастер 35, спортын мастер 250-иад төрөн гарсан байна. Тус тэнхимийн хичээл сургалтын үйл ажиллагаа нь оюутан залуусын эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэх, тэдний ажиллах чадварыг суралцах бүх хугацааны турш байнга өндөр түвшинд барьж байх, төгсөж гараад биеийн тамирын спортоор хичээллэх дадалтай болгоход чиглэдэг юм. Биеийн тамирийн хичээл нь оюутнуудыг хүмүүнлэг ёс, энх тайван, сайн санааны үзэл санааны үзлээр хүмүүжихэд чухал нөлөөлөл үзүүлдэг.

Тус тэнхим нь МУИС-ийн бүрэлдэхүүний 9 сургуулийн янз бүрийн мэргэжлийн ангиудад биеийн тамирын хичээлийг заахын сацуу улс, олон улсын хэмжээний томоохон тэмцээнүүдэд баг тамирчдыг бэлтгэн оролцуулах үүрэгтэйгээр ажилладаг.

Англи хэлний төв нь 1993 онд 4 багшийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж, МУИС-ийн хэлний бус мэргэжлийн нийт салбаруудын англи хэлний сургалтыг хариуцаж ирсэн. Англи хэлний төвийн багш нар МУИС-ийн 9 сургуулийн янз бүрийн мэргэжлийн 73 ангид хичээл зааж байна.

Төвийн үндсэн зорилт нь МУИС-ийн мэргэжлийн бүх факультетуудад үйлчлэх явдал бөгөөд үүний тулд хичээлийн иж бүрэн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан мөрдөх, англи хэлний болон мэргэжлийн бусад хичээлүүдийн залгамж холбоог хангах, багшах боловсон хучний мэргэжлийн түвшин, заах арга зүйг байнга дээшлүүлэх, сургалтын материалыг баазыг бүрдүүлэх зэрэг асуудлыг удирдлага болгодог. Тус төвөөс хэлний бус ангиудад ерөнхий болон бизнесийн англи хэлний хичээлийг анхан, дунд ба ахисан түвшинд заадаг. Мөн МУИС-ийн магистрант, докторант наарт ерөнхий болон мэргэжлийн англи хэлний хичээл зааж байна.

Тус төвийн багш нар англи хэлний заах аргыг сайжруулах, орчуулгын ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх арга замуудыг судлах чиглэлээр шинжилгээ судалгааны ажлуудыг хийж байна.

**Эдийн засгийн хүрээлэн** нь 1963 онд Монгол улсын ШУА-ийн харьцанд байгуулдсан. Тус хүрээлэн нь 1997 оноос МУИС-ийн ЭЗС-ийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Хийж гүйцэтгэсэн томоохон бүтээлүүд нь: "Монгол улсын эдийн засгийн хөгжлийн тойм ба прогноз" 50 боть, "Шинжлэх ухаан, техникийн хөгжлийн үндэсний хөтөлбөр" 28 боть.

#### Судалгааны хүрээ:

- Эдийн засгийн онол ба бодлого
- Хөгжлийн эдийн засаг
- Шилжилтийн эдийн засаг.

#### Судалгаа шинжилгээний ажлын ирээдүйн чиглэл:

- Монгол улс ба даяарчлал
- Монгол улсын эдийн засгийн хөгжилт
- Монгол улсын эдийн засгийн шинжлэх ухааныг хөгжүүлэх асуудлууд.

#### Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Тус хүрээлэн нь ОХУ-ын ШУА-ийн Эдийн засгийн хүрээлэн, БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн Эдийн засгийн засгийн хүрээлэн, Японы Засгийн газрын дэргэдэх Төлөвлөлтийн Газрын Судалгааны хүрээлэнгүүдтэй ажил хэргийн хэлхээ холбоотой ажилладаг.

**Судалгаа зөвлөгөө өгөх төв.** Сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь ЭЗС-ийн хөгжилд хувь нэмрээ оруулах, тус сургуулийн нэр хүнд болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино. Энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд дор дурдсан үндсэн үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- ЭЗС-ийн багш, ажилтнуудын судалгааны үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, сургууль төгсөгчдийн дипломын дараах сургалт зохион байгуулах;
- ЭЗС-ийн багш ажилтнуудын судалгаа, зөвлөгөө өгөх сонирхлыг тусгасан эдийн засгийн болон бизнесийн мэдээллийн тогтолцоог бий болгох, үнэлгээ, шинжилгээ хийх;
- Төрийн болон хувийн байгууллагад судалгаа болон зөвлөгөө өгөх, энэ үйл ажиллагаанд ЭЗС-ийн өндөр мэдлэг боловролтой хүчийг төвлөрүүлж ашиглах;

- Тодорхой сэдвээр семинар, бага хурал курс, ярилцлага зохион байгуулах, сурталчилгааны товхимол, танилцуулга гаргах;
  - Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;
  - Бусад үйл ажиллагаа зэрэг болно.

Төвийн зөвлөгөө өгөх үйлчилгээний төрлүүд:

- маркетинг, менежмент
  - санхүү
  - аудит
  - төсөлт боловсруулах
  - стратегийн болон бизнес төлөвлөгөө хийх
  - сургалт, судалгаа явуулах.

МУИС-ийн ЭЗС-ийн Судалгаа зөвлөгөө өгөх төв нь өөрийн үйлчилгээг бүх түвшний эдийн засгийн мэргэжилтнүүдэд, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдэд, хувь хүмүүст үзүүлдэг юм. Төвийн үйл ажиллагаанд ЭЗС-ийн бүх салбар нэгжүүд, профессор багш нар, ажилчид, оюутнууд оролцдог.

**Оюутны бие даан суралцах төв** нь Эдийн засгийн боловсролыг дэмжих TACIS төслийн хүрээнд оюутнуудад бие даан суралцахад нь туслах, оюуны хэрэгцээг нь хангаж, ном хэвлэл, мэдээллээр үйлчлэн тэдний дунд мэдээлэл, сурталчилгаа, сургалтын олон талт ажлыг явуулах зорилгоор байгуулагдсан соёл мэдээллийн байгууллага юм. Тус төв нь 1997 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж, ЭЗС-ийн оюутан, суралцагсдыг хэрэгцээт ном сэтгүүл, өдөр тутмын хэвлэл болон бие даан суралцах бусад материалыг агуулсан номын сангаар үйлчлэх, тэдэнд шаардлагатай бие даан суралцах болон алсын зайн сургалтын материал бэлтгэх чиглэлээр ажиллаж ирсэн билээ. Цаашид видео болон аудио техник хэрэгсэл, компьютерын программ хангамж, интернетийн сүлжээний тусlamжтайгаар бие даан суралцах болон сургалтын нөөц материалыуд бүхий мэдээллийн санг бурдуулж, түүгээрээ оюутанд үйлчлэх зорилт тавин ажиллаж байна.